



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 05 сарын 15 өдөр

Дугаар 220

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4, “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын нэгдүгээр төв эмнэлгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 60,930,000.00 (жаран сая есөн зуун гучин мянган) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашины 2 дахь дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э. Содномжамц, Улсын нэгдүгээр төв эмнэлгийн ерөнхий захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д. Очирбат нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц. Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.НЯМ-ОСОР

Э.ЭРДЭНЭХИШИГ

0001877



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн
2018.05.15 дугаар тогтоолын хавсралт

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ, СЭЛБЭГЭЭР АШИГЛАХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашини марк, улсын дугаар, зориулалт, арал, хөдөлгүүрийн дугаар | Ашиглалтад орсон он | Нийт гүйлт /км/ | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэгдэл өртөг (төгрөг) | Сэлбэгээр ашигласнаас олох орлого (төгрөг) |
|-----|---|---------------------|-----------------|--|--|-------------------------|---|
| 1 | Хьюндай старекс /түргэн тусламжийн/, 88-20 УНЗ, арал-КМJWA37RAAU25216, хөдөлгүүр-G4KGAА396391 | 2010 | 97 455 | 39 930 000,00 | 39 930 000,00 | - | 1 500 000,00 |
| 2 | Хьюндай элентра /суудлын/, 42-31 УБЛ, арал-КМНDU41BP8U2882398 хөдөлгүүр-2433887 | 2008 | 112 016 | 21 000 000,00 | 21 000 000,00 | - | 1 000 000,00 |
| | НИЙТ ДҮН | - | - | 60,930,000.00 (жаран сая есөн зуун гучин мянган) | 60,930,000.00 (жаран сая есөн зуун гучин мянган) | - | 2,500,000.00 (хоёр сая таван зуун мянган) |